



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 04

Мандалговь

Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн
түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. “Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ”-ийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Түрээслэгч-түрээслүүлэгчийн хооронд байгуулсан орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний түрээсийн төлбөрийн хэмжээ нь батлагдсан жишиг үнээс багагүй байхаар хянан баталгаажуулах, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

Гурав. Түрээсийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, батлагдсан жишиг үнээс багагүй байхаар байгуулан Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр)-аар батлуулан ажиллахыг Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, эрхлэгч нарт даалгасугай.

Дөрөв. Энэхүү тогоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 51 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцож, “Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ”-ийг 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын
24-ны өдрийн 2/2 тогтоолын хавсралт

Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн
түрээсийн төлбөрийн жишиг үнэ

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь санхүүгийн тайлан балансад тусгагдсан орон нутгийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг өмчийн бусад хэлбэрийн хуулийн этгээд иргэнд түрээслүүлэх төлбөрийн хэмжээг түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбарын чиглэлийг харгалзан дараах байдлаар тогтооно.

№	Түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбар, чиглэл, зориулалт	1 м.кв ашигтай талбайн түрээсийн төлбөрийн жишиг үнэ /төгрөг/	
1	Худалдаа, үйлчилгээ	5500	
2	Албан тасалгааны зориулалтаар	5000	
3	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	7500	
4	Тариалангийн талбай, хүлэмж	2000	
5	Орон сууц	Тухайн байгууллагын ажилтан болон төсвийн байгууллагын ажилтан	1500
		Бусад ¹	2500
6	Бусад	5000	

¹ орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмчлөлийн орон сууцыг эзэмшиж буй этгээд, түүний ажилладаг албан газартай гэрээ байгуулж төлбөр тооцоог хийлгэнэ/

2. Түрээсийн төлбөрийн жишиг үнийг дор дурдсан нөхцөлд дараах хувь хэмжээгээр бууруулан тогтоож болно:

2.1. Сумын төвд үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит хуулийн этгээдийн орон сууцнаас бусад түрээслүүлж буй байрны түрээсийн төлбөрийн жишиг үнийг 30 хувиар,

2.2. Орон нутгийн өмчийн бүртгэлд байгаа ашиглалтгүй барилга байгууламжийг түрээслэгчийн зардлаар засаж сэлбэн түрээслүүлэхэд /баримт нотолгоон дээр тулгуурлан/ түрээсийн төлбөрийн жишиг үнийг 20 хүртэл хувиар,

2.3. Барилгын туслах талбай /подвал, вестибюль гэх мэт/-г түрээслүүлэхэд төлбөрийн жишиг үнийг 20 хүртэл хувиар,

2.4. Төвлөрсөн системд холбогдоогүй орон сууцны барилгын төлбөрийн жишиг үнийг 20 хүртэл хувиар,

2.5. Спортын холбоо, нийтийн биеийн тамирын үйл ажиллагааны чиглэлээр түрээсэлж буй байгууллага, аж ахуйн нэгжийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг 40 хүртэл хувиар,

3. Орон нутгийн өмчийн байранд байрлаж буй төсөвт байгууллага, албан газрын ашиглаж байгаа өрөө тасалгааны 1 м.кв ашигтай талбайн түрээсийн төлбөрийг төсөвт тусгасан зардлыг харгалзан тогтоож болно.

4. Орон нутгийн өмчийн байранд байрлаж буй орон нутгийн өмчит байгууллагын байрны түрээсийн төлбөрийг төсөвт тусгаагүй бол ашиглалтын зардлаар тооцон гэрээ байгуулж болно.

5. Орон нутгийн өмчийн хөдлөх эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн хэмжээг ашиглалт үйлчилгээнд зарцуулах зардал болон хөдлөх хөрөнгийн эдэлгээний норм, тухайн эд хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл хорогдлын шимтгэл, ашиглалтын нөхцөл, зах зээлийн дундаж үнэ зэргийг харгалзан түрээслүүлэгч өөрөө тогтоож, Орон нутгийн өмчийн газраар баталгаажуулна.

6. Орон нутгийн өөрийн өмчийн байр талбайд суурилуулсан зар, сурталчилгааны самбарын түрээсийн төлбөрийг зах зээлийн дундаж үнэд тулгуурлан түрээслүүлэгч, түрээслэгч нар харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтооно.

7. Технологийн болон үйл ажиллагааны үндсэн чиглэлээс бусад зориулалтаар байр талбайг бусдад эзэмшүүлж ашиглуулахад түрээсийн гэрээ байгуулж түрээсийн орлогоос 30 хувийг орон нутгийн орлогод төвлөрүүлж байна.

8. Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг тухайн салбарын онцлогоос шалтгаалан өөрчлөх шаардлага гарвал орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд Орон нутгийн өмчийн газарт уламжлан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулж мөрдөж болно.